



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 10 өдөр

Дугаар А/467

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 72 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ковид-19 цар тахлын үеийн эмнэлгийн анхан шатны үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан өвчлөлийг бууруулах зорилгоор Жаргалант сумын Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгох санхүүгийн дэмжлэгт 50 000 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээг санхүүжүүлэх нийт 50 000 000 төгрөг /тавин сая/-ийг аймгийн техник хяналтын зардлын данснаас дараа тооцоогоор зохицуулж санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн техник хяналтын зардлаас дараа тооцоогоор санхүүжүүлсэн 50 000 000 төгрөгийг холбогдох байгууллагуудын зардлын батлагдсан эх үүсвэрээс нөхөн тооцоо хийж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Заг А/467 Кн  
02 2430

Аймгийн Засаг даргын 2021 оны  
09 дүгээр сарын 10-ны өдрийн  
А/467 дугаар захирамжийн хавсралт



ЖАРГАЛАНТ СУМЫН ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВҮҮДЭД ЭРГЭН  
ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙГЭЭР ОЛГОХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

Д/д	Өрхийн эмнэлгийн нэр	Хаяг	Эргэн төлөгдөх дэмжлэгийн дүн /төгрөг/
1	Рашаант ӨЭМТ	Жаргалант сум	10 000 000
2	Баатархайрхан ӨЭМТ	Жаргалант сум	10 000 000
3	Буянт ӨЭМТ	Жаргалант сум	10 000 000
4	Жаргалан ӨЭМТ	Жаргалант сум	10 000 000
5	Бугат ӨЭМТ	Жаргалант сум	10 000 000
Нийт дүн			50 000 000

-оОо-